

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл
ажиллагааны багц дүрэм”-д өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 60 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн дөрөвдүгээр хавсралт “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын 1.2 дахь хэсгийн “хэвлэмэл болон” гэснийг хассугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1 Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 251 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын 2.1.6 дахь заалтын “хэвлэмэл” гэснийг “цахим” гэж, 2.1.8 дахь заалтын “хэвлэмэл” гэснийг “цахимаар” гэж, 2.1.9 дэх заалтын “хэвлэмэл” гэснийг “цахимаар” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Мөн журмын хавсралтыг энэ тогтоолын хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.

3. Мөн журмын 2.1.1 дэх заалтын “, хэвлэмэл” гэснийг, 2.1.4 дэх заалтын “хэвлэмэл” гэснийг, 2.1.5 дахь заалтын “, хэвлэмэл” гэснийг тус тус хассугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны
... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын хавсралт

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06
дугаар сарын 25-ны өдрийн 251 дүгээр
тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн гаралтай
бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд
хяналт тавих журам”-ын хавсралт

ХОРООНД ИРҮҮЛЭХ МЭДЭЭ, ТАЙЛАН

№	Хороонд ирүүлэх мэдээллийн жагсаалт	Маягт	Ирүүлэх хэлбэр	Мэдээлэл ирүүлэх давтамж	Мэдээлэх хэлбэр	Ирүүлэх хугацаа
1	Биржийн товч танилцуулга	Журмын хавсралтын Маягт 1	Цахим	Улирал бүр	Өөрчлөлтийг тусгах	Дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор
2	Биржийн арилжааны мэдээ	Журмын хавсралтын Маягт 2	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
3	Биелээгүй захиалгын мэдээ	Журмын хавсралтын Маягт 3	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
4	Биржийн арилжаанд оролцогчдын мэдээ	Журмын хавсралтын Маягт 4	Цахим	Сар бүр	Өөрчлөлтийг тусгах	Дараа сарын 02-ны өдрийн дотор
5	Биржийн итгэмжлэл олгосон этгээдийн мэдээ	Журмын хавсралтын Маягт 5	Цахим	Сар бүр	Өөрчлөлтийг тусгах	Дараа сарын 02-ны өдрийн дотор
6	Улирлын санхүүгийн тайлан	СЯ-ны* А маягт Б маягт	Цахим	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор
7	Жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан	СЯ-ны* А маягт Б маягт	Хэвлэмэл	Жил бүр	Өссөн дүнгээр	Жил бүрийн нэгдүгээр улирлын дотор
8	Биржийн үйл ажиллагааны тайлан	Тайлан хэлбэрээр	Цахим	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор

9	Биржийн дотоод хяналтын тайлан	Тайлан хэлбэрээр	Цахим	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор
---	--------------------------------	------------------	-------	------------	---------------	--

Тайлбар: *Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан маягт.

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны ____ сар ____ өдөр

Дугаар ____

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 11.2 дахь хэсгийн “цаасан болон” гэснийг хассухай.

2. Мөн журмын хавсралтыг энэ тогтоолын хавсралтад заасны дагуу өөрчилсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны
... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын хавсралт

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 05 дугаар
сарын 07-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор
баталсан “Хөдөө аж ахуйн биржийн үйл
ажиллагааны зуучлагч /брокер/-ийн үйл
ажиллагааны зохицуулалтын журам”-ын хавсралт

ХОРООНД ИРҮҮЛЭХ МЭДЭЭ, ТАЙЛАН

№	Хороонд ирүүлэх мэдээллийн жагсаалт	Маягт	Ирүүлэх хэлбэр	Мэдээлэл ирүүлэх давтамж	Мэдээлэх хэлбэр	Ирүүлэх хугацаа
1	ХААБ-ийн үйл ажиллагаа явуулж буй компанийн танилцуулга	Журмын хавсралтын Маягт 1	Цахим	Улирал бүр	Өөрчлөлтийг тусгасан байна	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
2	Арилжааны тайлан	Журмын хавсралтын Маягт 2	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
3	Хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлсийн тайлан	Журмын хавсралтын Маягт 3	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
4	Биелээгүй захиалгын мэдээ	Журмын хавсралтын Маягт 4	Цахим	Долоо хоног бүр	Өссөн дүнгээр	Дараа долоо хоногийн мягмар гарагт
5	Хүний нөөцийн мэдээлэл	Журмын хавсралтын Маягт 5	Цахим	Улирал бүр	Өөрчлөлтийг тусгасан байна	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
6	Нэгдмэл сонирхолтой этгээдийн тухай мэдээлэл	Журмын хавсралтын Маягт 6	Цахим	Улирал бүр	Өөрчлөлтийг тусгасан байна	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
7	Улирлын санхүүгийн тайлан	СЯ-ны А маягт Б маягт	Цахим	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор
8	Аж ахуйн нэгжийн орлогын албан	ТЕГ-ын Маягт 1	Цахим, цаасаар	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын

	татварын тайлан, тодруулгын хамт	Маягт ТТ- 02г				эхний сарын 20- ны өдрийн дотор
9	Дотоод хяналтын шалгалтын тайлан	Тайлан хэлбэрээр	Цахим	Улирал бүр	Өссөн дүнгээр	Дараа улирлын эхний сарын 20- ны өдрийн дотор
10.	Жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан	СЯ-ны* А маягт Б маягт	Цаасаар	Жил бүр	Өссөн дүнгээр	Жил бүрийн нэгдүгээр улирлын дотор

Тайлбар: *Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан маягт.

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

“Даатгалын багц дүрэм”-д өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 66 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын 5.6.2, 5.6.3, 5.6.4 дэх заалтын “улирал бүр” гэсний дараа “цахимаар” гэж, мөн “Даатгалын багц дүрэм”-ийн дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-ын 3.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж, мөн “Даатгалын багц дүрэм”-ийн арван хоёрдугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын 5.4 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж, мөн “Даатгалын багц дүрэм”-ийн арван долоодугаар хавсралт “Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам”-ын 3.3 дахь хэсгийн “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж тус тус нэмсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан “Даатгалын багц дүрэм”-ийн хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын 3.1 дэх хэсгийн “цаасаар болон” гэснийг, мөн “Даатгалын багц дүрэм”-ийн аравдугаар хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ын 2.1 дэх хэсгийн “цаасаар болон” гэснийг, 2.3 дахь хэсгийн “Хороонд цаасаар ирүүлэх болон” гэснийг тус тус хассугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12^{1.7} дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 07 дугаар тогтоолоор баталсан “Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын 1.2, 2.1 дэх хэсгийн “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж тус тус нэмсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 286 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн 6.2 дахь хэсгийн “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж нэмсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 5.1 дэх хэсгийн “болон албан бичгээр” гэснийг хассугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 235 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 5.1 дэх хэсгийн “болон албан бичгээр” гэснийг хассугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны ____ сар ____ өдөр

Дугаар ____

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор баталсан “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны журам”-ын 2.25 дахь хэсгийн “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж нэмсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2026 оны ___ сар ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 3.1.7, Зээлийн батлан даалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 3.1 дэх хэсгийн “хэвлэмлээр болон” гэснийг хассугай..

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ